# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 01 өдөр Дугаар 240 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өвөрхангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 69,000,000.00 (жаран есөн сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 80-44 ӨВХ улсын дугаар, TRJ1500008703 арлын дугаартай, Тоёота ланд круйзер прадо маркийн тээврийн хэрэгслийг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, засан сэлбэн ашиглах зорилгоор Өвөрхангай аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга С.Цэдэнбалжир нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээд (Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газар)-д эзэмшүүлэх, засан сэлбэн ашиглах, үнийг шинэчлэн тогтоож данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл,удирдлага зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.4.Автотээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийг бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

13000780784

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн
240 дугаар тогтоолын хавсралт

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ТӨРИЙН ӨМЧИЙН ДАНС БҮРТГЭЛЭЭС ХАСЧ, ЗАСАН СЭЛБЭН АШИГЛАХ ЗОРИЛГООР ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ӨМЧИД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Автомашины нэр, марк, улсын дугаар, арал, хөдөлгөөрүүрийн дугаар | Явсан км-ийн заалт | Үйлдвэрлэсэн, ашиглалтанд орсон он | Балансын нийт үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тоёота ланд круйзер прадо 120, 80-44 ӨВХ /TRJ1500008703/ | 340,487 | 2010/2018 | 69,000,000.00 | 69,000,000.00 | - |
| **Нийт дүн** | | | | **69,000,000.00 (жаран есөн сая)** | **69,000,000.00 (жаран есөн сая)** | - |